



Арга хэмжээг байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулах нь

Хурал болон арга хэмжээг байгаль орчинд
ээлтэй байдлаар зохион байгуулахад анхаарах
зүйлс

2023 оны 6 дугаар сар
Улаанбаатар, Монгол улс

АГУУЛГА

I.	Удиртгал.....	3
II.	Арга хэмжээг байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулахад анхаарах зүйлс	5
1.	Хуванцар савтай ус хэрэглэхгүй байх	5
2.	Хуванцар савтай ундаа, шүүс хэрэглэхгүй байх	5
3.	Нэг удаагийн хуванцар ууттай цай, кофе, сүү, элсэн чихрээс татгалзах	6
4.	Хуванцрын орцтой сав, баглаа боодолтой хөнгөн зууш болон амттанаас зайлсхийх.....	7
5.	Нэг удаагийн аяга, таваг, халбага, сэрээ, хутга болон соруул хэрэглэхээс татгалзах	7
6.	Гялгар уут хэрэглэхээс зайлсхийх.....	8
7.	Хулдаасан материалаар хийсэн баннерын хэрэглээнээс татгалзах	8
8.	Аливаа материалыг хэвлэхээс зайлсхийх.....	8
9.	Дэвтэр, үзэг гэх мэт зүйлсийг түгээхээс татгалзах	9
III.	Дүгнэлт	10
	Хавсралт 1: Арга хэмжээний дараа энэхүү зөвлөмжийн хэрэгжилт хэр түвшинд байсныг дүгнэх хуудас	11
	Хавсралт 2 : Хурлын төлөөлөгчдөөс өөрсдөө авчрахыг хүсэх зүйлс	13
	Хавсралт 3: Улаанбаатар хотод дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд.....	14

I. Удиртгал

Дэлхийн хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1960-аад оноос хойш 20 дахин нэмэгдэж, 2018 онд 359 сая тоннд хүрчээ. Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-аас 2050 он гэхэд хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд газрын тосны нийт хэрэглээний 20 хувийг зарцуулагдана хэмээн мэдэгдээд байна.

Гэвч дэлхийн хуванцар хог хаягдлын 91% нь дахин боловсруулагдахгүйгээр хаягддаг хэвээр байна. ДЭЗФ-ын тооцоолсноор, хог хаягдлын дахин боловсруулалт бага, харин түүнийг булах, шатаах түвшин өндөр байгаагаас үүдэлтэй эдийн засгийн алдагдал нь жил бүр 70-105 тэрбум ам.долларт хүрч байна. 2012 оны тоо мэдээллээс харахад хуванцарын үйлдвэрлэл болон хуванцар хог хаягдлыг шатааснаас үүдэн жил бүр 400 сая орчим тонн нүүрс хүчлийн хий ялгардаг байна. Энэ нь дэлхийн дулаарал, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн гол эх үүсвэрүүдийн нэг болж байна. Цаашлаад, хуванцар нь далайн болон хуурай газрын амьтан, ургамлын амьдралд болон хүний эрүүл мэндэд ихээхэн аюул заналыг учруулж байна¹.

Эдгээр нөхцөл байдал нь биднээс хуванцар бүтээгдэхүүний хэрэглээгээ бууруулж, цаашид хэрэглээнээсээ хасахыг шаардаж байна. Иймд нэг удаагийн хуванцар сав, баглаа боодолтой зүйлсийг хэрэглэхгүйгээр аливаа нэг хурал, арга хэмжээг зохион байгуулснаар бид хог хаягдлыг багасгаж, байгаль орчноо хамгаалахад хувь нэмэр оруулж, цаашлаад байгалийн баялгийг хойч үедээ хадгалан үлдээж, Монголын уламжлалт нүүдэлчин соёлыг хадгалан үлдэхэд ч мөн адил ач холбогдолтой юм². Аливаа арга хэмжээг байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулахын тулд илүүдэл хэрэглээнээсээ татгалзаж, шаардлагатай тохиолдолд хуванцарын оронд цаас гэх мэт сэргээгдэх түүхий эдийг ашиглах нь зүйтэй юм. Цахим ертөнц хөгжиж буй өнөөгийн цаг үед, хурлын хөтөлбөр, баннер гэх мэт зүйлсийг хэвлэхээс аль болох татгалзаж, цахим хэлбэрээр түгээн хэрэглэх нь илүү оновчтой юм. Үүнээс гадна хог хаягдлыг бууруулах өөр олон боломжууд байдаг. Үүний нэг нь тухайн зүйлийг зайлшгүй хэрэглэх шаардлагатай эсэхийг тунгаан бодож, хэрэв татгалзах боломжтой бол түүнийг хэрэглэхээс бүр мөсөн татгалзах эсвэл түүнийг байгаль орчинд ээлтэй хувилбараар орлуулах явдал юм.

Энэхүү зөвлөмжид аливаа нэг хурал, арга хэмжээг байгаль орчинд ээлтэй бөгөөд хог хаягдал багатайгаар зохион байгуулахад тус дөхөм болох арга замуудыг тусгаж, үүгээр дамжуулан дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, цаашлаад тогтвортой хөгжлийн холбогдох зорилтуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулсан болно.

¹ <https://data.europa.eu/doi/10.2779/800074> (2023 оны 3 дугаар сар)

² <http://plastic-recycling.mn/api/v1/getImage/?file=202206280502590202.pdf> (2023 оны 3 дугаар сар)

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлснээр ТХЗ-ын дараах зорилгуудад хувь нэмэр оруулах юм. Үүнд:

11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES



Зорилго 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих

Хот, хүн амын суурьшлыг бүх талын оролцоог хангасан, аюулгүй, эрсдэлийг даван туулах чадвартай, тогтвортой болгох

Хуванцар сав, дахин боловсруулах боломжгүй баглаа боодлын хэрэглээг багасгах нь хотуудын тогтвортой менежментэд хувь нэмэр оруулж, үйл ажиллагаа явуулахад таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Ингэснээр хог хаягдлын менежмент сайжирч, хуванцар хог хаягдлаас үүдэлтэй хотын бохирдол багасна.

12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION



Зорилго 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтцийг бүрдүүлэх

Энэхүү зөвлөмж нь хуванцар сав баглаа боодлыг хэрэглэх зайлшгүй шаардлагатай эсэхийг тунгаан бодоход тусалж, түгээмэл хэрэглэгддэг, хуванцар бүтээгдэхүүнийг байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнээр солих болон орлуулах боломжит хувилбаруудыг харуулах замаар үйлдвэрлэл, хэрэглээний мөчлөгийг өөрчлөхөд хувь нэмэр оруулна.

13 CLIMATE ACTION



Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах

Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар яаралтай арга хэмжээ авах

Уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтний өмнө тулгарч буй томоохон сорилтуудын нэг бөгөөд байгаль орчин, хүний эрүүл мэнд, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Хуванцрын хэрэглээнээс үүдэлтэй хог хаягдлыг багасгах нь түүнийг үйлдвэрлэх, тээвэрлэхэд шаардлагатай газрын тос, эрчим хүчний зарцуулалтыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын эсрэг нөлөөлөх нэгэн чухал хүчин зүйл болох юм.

14 LIFE BELOW WATER



Зорилго 14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах

Тогтвортой хөгжлийн зорилгоор далай, тэнгис, далайн нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах

Хуванцар нь далайн бохирдлын 80 гаруй хувийг эзэлдэг. Гэвч зарим судалгаагаар микропластик нь усыг бохирдуулж, улмаар гол горхи, нуурын ургамал, амьтдын амьдралд төдийгүй усны ойролцоо амьдардаг хүмүүсийн эрүүл мэндэд ихээхэн аюул занал учруулж байгааг онцолж байна.

15 LIFE ON LAND



Зорилго 15. Хуурай газрын экосистемийг хамгаалах

Дэлхийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, түүний тогтвортой хэрэглээг дэмжих, ойг тогтвортой ашиглах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоох, сэргээх, биологийн олон янз байдал алдагдаж буйг зогсоох

Хуванцрын хэрэглээ, бохирдол нь далай тэнгис, хуурай газрын амьдралд сөргөөр нөлөөлдөг. Байгальд хаясан хуванцар болон хогийн цэгт хаягдсан микропластик, хорт болон химийн бодис нь хөрс, гол горхи, нуурын усаар дамжин ургамал, амьтан, хоол хүнсэнд сөрөг нөлөө үзүүлж байна.

II. Арга хэмжээг байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулахад анхаарах зүйлс

1. Хуванцар савтай ус хэрэглэхгүй байх

Хуванцар савыг ихэвчлэн нефтийн гаралтай, нөхөн сэргээгдэхгүй хуванцар, полиэтилен материалаар хийдэг. Иймд хуванцар савны хэрэглээг багасгах нь түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай газрын тосыг хэмнэж, нөхөн сэргээгдэхгүй полиэтилен материалын хэрэглээг багасгах ач холбогдолтой. Дэлхий дээрх хуванцар савны дөнгөж 9% нь дахин боловсруулагддаг гэсэн тооцоо бий. Үүнээс байгалийн нөөцийг тогтворгүй ашиглаж, байгаль орчны бохирдол ихсэж байгаа нь харагдаж байна. Хуванцрын хог хаягдал нь аюултай, химийн хорт бодис ялгаруулж, улмаар амьтан, ургамалд аюул учруулдаг. Байгальд хаясан хуванцар болон хогийн цэгт хаягдсан микропластик, хорт болон химийн бодис нь хөрс, гол горхи, нуурын усаар дамжин ургамал, амьтан, хоол хүнсэнд сөрөг нөлөө үзүүлдэг.



Иймээс аливаа арга хэмжээний хүрээнд оролцогчдод нэг удаагийн хуванцар савтай ус өгөхөөс татгалзах нь зүйтэй. Харин үүний оронд дахин ашиглах боломжтой зэвэрдэггүй ган, эсвэл шилээр хийсэн олон литрийн багтаамжтай сав ашиглаж, хажууд нь дахин ашиглах боломжтой аяга, стакан зэргийг тавих нь илүү тохиромжтой. Эсвэл та зочдоосоо дахин ашиглах боломжтой усны савыг өөрсдөө авчрахыг хүсэх боломжтой. Ингэснээр аяга, стакан зэргийг цэвэрлэхэд шаардлагатай эрчим хүч, материал хэмнэгдэх болно.

2. Хуванцар савтай ундаа, шүүс хэрэглэхгүй байх

Хуванцар савтай ундаа, шүүс нь дээр дурдсантай адил сөрөг нөлөөтэй. Тиймээс тухайн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн газартайгаа хамтран үүнийг орлуулж болох бусад боломжуудыг судалж үзэх нь зүйтэй. Тухайлбал, дахин ашиглах боломжтой зэвэрдэггүй ган эсвэл шилээр хийсэн олон литрийн багтаамжтай шүүсний сав ашиглах боломжтой. Эсвэл лааз, шил, хөнгөн цагаан зэрэг дахин боловсруулах боломжтой материалаар хийсэн савтай ундаа, шүүсийг тавих нь зүйтэй. Ийм тохиолдолд шилэн лонх, хөнгөн цагаан лааз зэргийг цуглуулж, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хүргүүлэх боломжтой (Улаанбаатар хотын хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг

байгууллагуудын талаарх мэдээллийг Хавсралт 3-аас харна уу).

3. Нэг удаагийн хуванцар ууттай цай, кофе, сүү, элсэн чихрээс татгалзах

Бидний түгээмэл хэрэглэх болсон "3 in 1" багц дахь нэг удаагийн кофе, сүү, элсэн чихрийг тус тусад нь савласан байдаг бөгөөд энэхүү савлагаа нь дахин боловсруулах боломжгүй хуванцар материалаар хийгдсэн байдаг. Энэ нь их хэмжээний хог хаягдлыг бий болгодог тул түүнийг хэрэглэхээс аль болох татгалзах хэрэгтэй. Харин үүний оронд байгальд задардаг



материалаар хийсэн эсвэл том савлагаатай кофе, сүү, элсэн чихрийг сонгох хэрэгтэй. Тухайлбал, кофег халуун саванд, сүүг том шилэн саванд хийж үйлчлэх боломжтой.

Нэг удаагийн савлагаатай цайнаас яагаад зайлсхийх ёстой вэ?

Цайны уутыг ихэвчлэн холимог материалаар хийдэг бөгөөд уутных нь дөрөвний нэг нь хуванцар байдаг. Энэ хэсэг нь байгальд задардаггүй тул хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Канадын судлаачид нэг удаагийн савлагаатай цайны нэг уутнаас 11.6 тэрбум "микрочастиц" болон 3.1 тэрбум "наночастиц" гэж нэрлэгддэг жижиг хэсгүүд ялгардаг болохыг тогтоожээ³.



Тиймээс, жижиглэн савласан нэг удаагийн цайнаас татгалзаж, төмөр эсвэл цаасаар хийсэн том сав, баглаа боодолтой эсвэл задгай цай хэрэглэх нь бидний эрүүл мэнд болон байгаль орчинд илүү ээлтэй юм.

³ <https://doi.org/10.1021/acs.est.9b02540>

4. Хуванцрын орцтой сав, баглаа боодолтой зууш болон амттанаас зайлсхийх

Хуванцар сав, баглаа боодолтой жигнэмэг болон зууш нь хог хаягдлыг ихээр бий болгохын сацуу бидний эрүүл мэндэд аюултай. Тиймээс ийм төрлийн хүнсийг байгальд задардаг төмөр юмуу, цаасан савлагаатай жигнэмэг болон зуушаар орлуулах нь зүйтэй.




Нэг бүрчлэн савласан хуванцар сав, баглаа боодолтой зууш, амттанг хэрэглэхгүй байх замаар та зочдынхоо болон хүрээлэн буй орчныхоо сайн сайханд хувь нэмэр оруулах боломжтой бөгөөд дахин ашиглах боломжтой саванд савласан хөнгөн зууш, хүнсээр үйлчилдэг байгууллагуудтай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй юм.

5. Нэг удаагийн аяга, таваг, халбага, сэрээ, хутга болон соруул хэрэглэхээс татгалзах

Далайн хог хаягдлын 80 гаруй хувь нь хуванцраас бүрддэг бөгөөд энэ нь жил бүр 8 тэрбум орчим тонноор нэмэгдэж байдаг. Далайд гарцгүй орнуудад ч мөн адил хуванцар сав баглаа боодлоос гарсан хог хаягдал ихсэж, байгаль орчин, ан амьтан, хүний эрүүл мэндэд заналхийлж байна. Иймд хуванцар савны хэрэглээг багасгахад хүн бүр хувь нэмэр оруулах хэрэгтэй юм⁴.

Тухайлбал, хуванцар соруул нь овор багатай, хөнгөн жинтэй учир газар сайгүй хаягдаж, байгаль орчинд хог хаягдал болон үлдэх нь элбэг байдаг. Иймд арга хэмжээнд оролцогчдод хоол захиалахдаа нэг удаагийн сав баглаа боодолтой хоолноос зайлсхийж, оронд нь ган төмөр, шил, шаазан, керамик материалаар хийсэн аяга, таваг, халбага сэрээ ашигладаг байгууллагыг сонгож, хамтран ажиллах нь чухал юм. Хэрэв боломжгүй бол байгальд задардаг нэг удаагийн хувилбаруудаас сонгох нь зүйтэй.



⁴ <https://www.science.org/doi/10.1126/science.1260352>

6. Гялгар уут хэрэглэхээс зайлсхийх

Гялгар уут нь байгаль орчныг хамгийн их бохирдуулдаг хог хаягдлын тоонд ордог боловч энэ нь бид үүнийг түгээмэл хэрэглэсээр байна. Иймд гялгар уутны оронд байгальд задардаг цаасан болон сүрлэн материалаар хийсэн уутыг хогийн уут болгон ашиглах нь илүү тохиромжтой.



Харин бидний өдөр тутмын хэрэглээнд гялгар уутны оронд удаан хугацаанд ашиглах боломжтой даавуун уут хэрэглэх нь байгаль орчинд ээлтэй хувилбар юм. Гэсэн хэдий ч даавуун уутыг үйлдвэрлэхэд энерги их шаарддаг тул хэрэв зайлшгүй шаардлагагүй бол үүнээс ч мөн зайлсхийх нь зүйтэй.

7. Хулдаасан материалаар хийсэн баннерын хэрэглээнээс татгалзах

Хулдаасан баннер нь хэд хэдэн давхарга болон өнгө будаг агуулдаг тул дахин боловсруулах боломжгүй байдаг. Тиймээс оронд нь ЛЕД дэлгэц ашиглах эсвэл проектор ашиглан баннерыг харуулах боломжтой. Хэрэв дэлгэцээр харуулах боломжгүй бол хуванцрын орцгүй, байгальд задардаг материалаар хийсэн баннерыг сонгох нь зүйтэй. Өөр нэг хувилбар нь дахин ашиглах боломжтой, ерөнхий загвартай баннер хэвлүүлж, байгууллагаасаа зохион байгуулдаг бүх хурал, арга хэмжээнд ашиглах боломжтой юм.



8. Аливаа материалыг хэвлэхээс зайлсхийх

Хурал, зөвлөгөөнийг зохион байгуулахдаа хөтөлбөр, оролцогчдын нэр, тайлан, танилцуулга зэргийг хэвлэн тараах нь түгээмэл байдаг. Гэвч эдгээр материалыг хэвлэн тараахын оронд цахимаар (имэйл болон бусад том

файлуудыг илгээх боломжтой цахим платформуудыг ашиглан) түгээх замаар цаас болон принтерийн хорыг хэмнэх боломжтой юм.


Ингэхдээ холбогдох материалуудыг pdf форматаар түгээх нь илүү тохиромжтой бөгөөд ингэснээр оролцогчид гар утас болон бусад төхөөрөмжөө ашиглан тухайн файлуудаа хялбар нээж хэрэглэх боломжтой болох юм.

Оролцогчдод мандат өгөх нь бие биенээ таньж мэдэхэд тустай боловч оролцогчдын жагсаалтыг урьдчилан имэйлээр илгээх замаар мандатыг хэвлэн түгээхээс ч мөн татгалзах боломжтой.



9. Дэвтэр, үзэг гэх мэт зүйлсийг түгээхээс татгалзах

Аливаа нэг хурал, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулахад арга хэмжээнд оролцогчдод дэвтэр, бал тараах нь түгээмэл байдаг. Гэвч энэ нь зайлшгүй шаардлагатай эсэхийг тунгаан бодож, болж өгвөл үүнээс татгалзах нь зүйтэй юм. Харин үүний оронд арга хэмжээнд оролцох хүмүүстэй урьдчилан имэйлээр холбогдож, тэмдэглэлийн дэвтэр болон балыг өөрсдөө авчрахыг хүсэх нь зүйтэй. Зөөврийн компьютер, таблет гэх мэт цахим, цаасгүй шийдлүүдийг ашиглах боломжууд нэмэгдсээр байгаа өнөөгийн дижитал эрин зуунд дэвтэр, үзэг, бал зэрэг төдийлөн шаардлагагүй зүйлсийг түгээхээс татгалзах боломжтой юм.



III. Дүгнэлт

Уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн хомсдол, байгалийн нөөцийн хэт ашиглалт, бохирдол зэрэг нь Монгол Улс төдийгүй дэлхий дахинд тулгарч буй сорилтууд юм. Иймээс бид аливаа арга хэмжээг хуванцаргүй, байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулахад анхаарлаа хандуулах нь нэн чухал болоод байна. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ нэг удаагийн хуванцар материалын хэрэглээнээс үүдэлтэй сөрөг талууд болон эдгээр материалыг орлуулан хэрэглэхэд шаардлагатай зүйлсийн орон нутгийн чанартай хүчин зүйлсийн хүртээмжийг харгалзан үзэхийг танд зөвлөж байна.

Мөн энэхүү зөвлөмжид хавсаргасан дүгнэх хуудсыг бөглөх замаар тус зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж, тулгарсан болон цаашид тулгарч болзошгүй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг хайж ажиллахыг санал болгож байна.

Хавсралт 1: Арга хэмжээний дараа энэхүү зөвлөмжийн хэрэгжилт хэр түвшинд байсныг дүгнэх хуудас⁵

Хурлын огноо:	Оролцогчдын тоо:	Хянасан:
Байршил:		

Эд зүйлс, хэрэгсэл	Байгаль орчинд халтай	Боломжийн	Байгаль орчинд ээлтэй
Ус, ундаа	<ul style="list-style-type: none"> ▫ Хуванцар савтай ус, ундаа 	<ul style="list-style-type: none"> ▫ Шилэн лонх эсвэл хөнгөн цагаан лаазтай шүүс/ундаа 	<ul style="list-style-type: none"> ▫ Усны том сав, дахин ашиглах боломжтой сав эсвэл шилэн аяга ▫ Дахин ашиглах боломжтой шилэн савтай шүүс/ундаа
Цай, кофе элсэн чихэр, сүү	<ul style="list-style-type: none"> ▫ Нэг удаагийн хуванцар эсвэл гялгар ууттай “3 in 1” кофены багц ▫ Нэг удаагийн цай ▫ Нэг удаагийн элсэн чихэр ▫ Нэг удаагийн сүү 	<ul style="list-style-type: none"> ▫ Том гялгар уутанд савласан кофе ▫ Том тунгалаг гялгар уутанд савласан цай ▫ Байгальд задардаг том тунгалаг гялгар уутанд савласан элсэн чихэр ▫ Том тунгалаг гялгар уутанд савласан элсэн чихэр ▫ Байгальд задардаг уут эсвэл хөнгөн цагаан лаазанд савласан сүү 	<ul style="list-style-type: none"> ▫ Шилэн савтай эсвэл байгальд задардаг уутанд савласан кофе ▫ Шилэн савтай эсвэл байгальд задардаг уутанд савласан цай ▫ Байгальд задардаг уутанд савласан элсэн чихэр ▫ Дахин ашиглах боломжтой шилэн лонх эсвэл халуун саванд савласан сүү

⁵ Эх сурвалж: <https://www.undp.org/laopdr/publications/guideline-plastic-free-meeting> (2023 оны 3 дугаар сар)

Эд зүйлс, хэрэгсэл	Байгаль орчинд халтай	Боломжийн	Байгаль орчинд ээлтэй
Зууш	<ul style="list-style-type: none"> ▫ Хуванцар савлагаатай зууш, хүнсний зүйлс (чихэр, печень, нарийн боов г.м.) 	<ul style="list-style-type: none"> ▫ Хуванцар савлагаагүй, дахин ашиглах боломжтой гялгар уутанд хийсэн зууш 	<ul style="list-style-type: none"> ▫ Зэвэрдэггүй том ган сав зэрэг дахин ашиглах боломжтой, байгальд задардагсав баглаа боодолтой хүнс, зууш
Хоолны хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> ▫ Нэг удаагийн хуванцар халбага, сэрээ, хутга ▫ Хуванцар соруул ▫ Хуванцар эсвэл хуванцар доторлогоотой нэг удаагийн таваг, аяга, поднос 	<ul style="list-style-type: none"> ▫ Хулс гэх мэт байгальд задрах материалаар хийсэн нэг удаагийн халбага, сэрээ, хутга ▫ Хулс гэх мэт байгальд задрах материалаар хийсэн нэг удаагийн аяга, таваг, поднос 	<ul style="list-style-type: none"> ▫ Модон эсвэл зэвэрдэггүй ган халбага ▫ Модон эсвэл зэвэрдэггүй ган сэрээ ▫ Модон эсвэл зэвэрдэггүй ган хутга ▫ Хулсан эсвэл зэвэрдэггүй ган соруул ▫ Дахин ашиглах боломжтой таваг, аяга, поднос
Хогийн уут	<ul style="list-style-type: none"> ▫ Гялгар уут 	<ul style="list-style-type: none"> ▫ Дахин боловсруулсан материалаар хийсэн гялгар уут 	<ul style="list-style-type: none"> ▫ Байгальд задардаг материалаар хийсэн хогийн уут ▫ Цаас эсвэл гадил жимсний навчаар хийсэн уут ▫ Хогийн саванд гялгар уут хэрэглэхгүй байх
Хурлын баннер	<ul style="list-style-type: none"> ▫ Хулдаасан, хуванцар материалтай баннер 	<ul style="list-style-type: none"> ▫ Байгальд задардаг материалаар хийсэн, дахин ашиглах боломжтой загвар бүхий баннер 	<ul style="list-style-type: none"> ▫ ЛЕД дэлгэц, проектор ашиглаж баннерийг харуулах

Хавсралт 2 : Хурлын төлөөлөгчдөөс өөрсдөө авчрахыг хүсэх зүйлс

- Усны сав
- Дэвтэр, бал
- Хөтөлбөр, илтгэл гэх мэт арга хэмжээний талаарх мэдээллийг агуулсан файлуудыг цахимаар татаж авсан байх

Хавсралт 3: Улаанбаатар хотод дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд

Дахин боловсруулах боломжтой материалыг ашигласны дараа хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг зохих байгууллагуудад хүргүүлэх шаардлагатай учраас аливаа арга хэмжээний дараа цугласан хог хаягдлыг ангилах нь нэн чухал юм. 2021 онд Монгол Улс дахь Бүгд Найрамдах Чех Улсын Каритас байгууллагаас гаргасан удирдамжид хог хаягдлыг хуванцар, цаас, шил болон лааз гэсэн үндсэн 4 төрлөөр ангилахыг зөвлөсөн байдаг⁶.

Хотын тохижилт үйлчилгээний компани (ТҮК)-аас гадна Улаанбаатар хотод хог хаягдал цуглуулах хэд хэдэн цэг болон аж ахуйн нэгжүүд байдаг бөгөөд тэдэнтэй холбогдож ангилсан хог хаягдлаа өгөх боломжтой. Дараах хог хаягдал цуглуулах цэгүүд болон аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг дээр дурдсан Бүгд Найрамдах Чех Улсын Каритас байгууллагаас гаргасан удирдамжид үндэслэн гаргасан болно.

Хог хаягдал цуглуулах цэгүүд

- Баянзүрх болон Сүхбаатар дүүрэг: +976 88704841
Сонгинохайрхан дүүрэг: +976 99991712
- Чингэлтэй дүүрэг: +976 88709002
- Хан-Уул дүүрэг: +976 88165252\
- Налайх дүүрэг: +976 88080373

Хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг компаниуд

1. Mog Plastic ХХК (шил, лааз, хуванцар)

[fb.com/mogplastic](https://www.facebook.com/mogplastic)
+976 88773223, +976 80076550

2. Eco City Selection ХХК (цаас)

[fb.com/profile.php?id=10007265979441](https://www.facebook.com/profile.php?id=10007265979441)
+976 98112689, +976 86818123

3. Түвшин Сайхан Төв (шил, лааз, хуванцар, цаас)

[fb.com/tuvshinsaikhancenter](https://www.facebook.com/tuvshinsaikhancenter)
+976 9668 5858